



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 4/12

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, "Сангийн дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм"-ийн 4.3.2 дахь заалт болон Сангийн зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Энэхүү тушаалын хавсралт жагсаалтад дурдсан нэр бүхий 4 иргэнтэй холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай 6,000,000 /зургаан сая/ төгрөгийг "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-гаас гаргахыг Сангийн зөвлөлийн гишүүн, Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяад зөвшөөрсүгэй.

2. Сангаас гаргах хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, Консулын газрын захирал Б.Болд, Сангийн зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяа нарт даалгасугай.

САЙД



Б.БАТЦЭЦЭГ

10-2022-30

**“ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ТУСЛАХ САН”-ГИЙН
ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ 1 ДҮГЭЭР ХУРЛААР ХЭЛЭЛЦЭН ШИЙДВЭРЛЭСЭН ТУСЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хаана, хэнд олгох	Олгох тусламжийн хэмжээ төгрөгөөр
“Дүрмийн 4.3.2. заалт буюу хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, алан хядах ажиллагаа, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, сэтгэцийн өвчтэй болсон, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаах” гэснийг үндэслэн;		
1	Украинаас Польшид дүрвэж ирсэн иргэн Д.Г-ын буцах зардалд дэмжлэг үзүүлэх,	1,500,000 төгрөг
2	Украинаас Польшид дүрвэж ирсэн иргэн Х.Г-ын буцах зардалд дэмжлэг үзүүлэх,	1,500,000 төгрөг
3	Украинаас Польшид дүрвэж ирсэн иргэн Ж.О-гийн буцах зардалд дэмжлэг үзүүлэх,	1,500,000 төгрөг
4	Украинаас Польшид дүрвэж ирсэн иргэн Х.Г-ын буцах зардалд дэмжлэг үзүүлэх,	1,500,000 төгрөг
Дүн		6,000,000 төгрөг

Нийт дүн **6,000,000** /зургаан сая/ төгрөг



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 29 өдөр

Дугаар

А/18

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, "Сангийн дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм"-ийн 4 дүгээр зүйл болон Сангийн зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 2 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Энэхүү тушаалын хавсралт жагсаалтад дурдсан нэр бүхий 11 иргэнтэй холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай 43,970,300 /дөчин гурван сая есөн зуун далан мянга гурван зуун/ төгрөгийг "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-гаас гаргахыг Сангийн зөвлөлийн гишүүн, Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяад зөвшөөрсүгэй.

2. Сангаас гаргах хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, Консулын газрын захирал Б.Болд, Сангийн зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяа нарт даалгасугай.

САЙД



Б.БАТЦЭЦЭГ

10122004.

**“ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ТУСЛАХ САН”-ГИЙН
ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ 2 ДУГААР ХУРЛААР ХЭЛЭЛЦЭН ШИЙДВЭРЛЭСЭН ТУСЛАМЖИЙН ЖАГСААЛТ**
Нийт дүн 43,970,300 /дөчин гурван сая есөн зуун далаг мянга гурван зуу/ төгрөг

д/д	Хаана, хэнд олгох	Олгох тусламжийн хэмжээ төгрөгөөр
“Дүрмийн 4.3.1. буюу хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарилыг эх оронд нь буцаах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл садан нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах” гэсэн заалтыг үндэслэн;		
1	БНСУ-д сурч байх хугацаандаа цусны цочмог хурц хавдраар өвдөж 2022.01.03-нд нас барсан иргэн С.Р-ын шарилыг эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	4,295,600 төгрөг
2	Москва хотод 2022.02.13-ны өдөр нас барсан ганц бие, эх орны дайны ахмад зүтгэлтэн Ц.Д /99 настай/-г нь оршуулахад гарсан зардлын тодорхой хэсэг,	10,000,000 төгрөг
3	2017 онд БНЧУ-д хөдөлмөрийн гэрээгээр явж, тэндээ ажиллаж байх хугацаандаа 2021.12.27-нд Чехийн Страж под Ралскем газар өөрийн амьдарч байсан байрандаа зуурдаар нас барсан Ч.С-ийн шарилыг эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	3,324,700 төгрөг
4	Хөхний хорт хавдрын улмаас 2021.11.07-нд Польшид нас барсан иргэн Ж.Н-г оршуулахтай холбоотой зардлын тодорхой хэсэг,	4,350,000 төгрөг
5	2022.03.01-нд Турк руу наймаа хийж амьдралаа залгуулахаар яваад 2022.03.09-нд нас барсан С.Г-ын шарилыг нь эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,500,000 төгрөг
4.3.3. хилийн чанадад хорих ял эдэлж байгаад, эсхүл албадан саатуулагдаж байгаад суллагдсан иргэнийг эх оронд нь буцаах; гэснийг үндэслэн;		
6	Вьетнамын шоронд ял эдэлж багаад 2021 оны 08 дугаар сарын 24-нд ялын хугацаа нь дууссан иргэн О.Ө-ын Монгол руу буцах зардал,	3,000,000 төгрөг
4.3.6. хилийн чанадад гэмт хэргийн улмаас хохирсон иргэнтэй холбоотой асуудлыг тухайн улсын холбогдох хууль хяналтын байгууллагаар хянуулах, эрх ашгийг нь хамгаалахад шаардагдах өмгөөлөгч, орчуулагчийг хөлслөх;		
7	К.Баясалыг эцэг нь болох Япон Улсын иргэн Ватанабэ Кикүотой Япон руу хамт явуулан буцааж авч чадахгүй байгаа иргэн Ё.О-лийн өмгөөллийн зардлын тодорхой хэсэг,	3,000,000 төгрөг
8	БНСУ-д 2022 оны 01 дугаар сарын 14-нд үйлдвэрийн ослоор баруун гарын 3 хуруугаа тайруулсан иргэн Ц.О-гийн өмгөөллийн төлбөрийн тодорхой хэсэг,	3,000,000 төгрөг
9	ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хотод нөхөр болох БНХАУ-ын иргэн Ван Рунняньгийн байнгын дарамт, хүчирхийлэлд өртдөг Г.Г-д үзүүлэх дэмжлэг,	500,000 төгрөг
“Дүрмийн 4.3.2. заалт буюу хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, алан хядах ажиллагаа, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, сэтгэцийн өвчтэй болсон, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаах” гэснийг үндэслэн;		
10	БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаад 2022 оны 01 дүгээр сарын 14-нд өндрөөс унаж хүнд гэмтэл авч тархины хагалгаанд орж эмчилгээ хийлгэж байгаа О.Н-ын эмчилгээний зардлын тодорхой хэсэг,	4,000,000 төгрөг
11	Тайваньд унадаг дугуйнаас унаж бэртэн мэс засалд орсон оюутан Т.Н-ийн эмчилгээний зардлын тодорхой хэсэг,	3,000,000 төгрөг
Дүн		43,970,300 төгрөг



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САГДИЙН
ТУШААЛ

2022 оны 07 сарын 01

A/50

УЛСЫН ГАЗРЫН САХИМ

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, "Сангийн дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм"-ийн 4 дүгээр зүйл болон Сангийн зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь

1 Энэхүү тушаалын хавсралт жагсаалтад дурдсан нэр бүхий 11 иргэнтэй холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай **45,700,000** /дөчин таван сая долоон зуун мянга/ төгрөгийг "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-гаас гаргахыг Сангийн зөвлөлийн гишүүн, Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х Алтантуяад зөвшөөрсүгэй

2. Сангаас гаргах хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, Консулын газрын захирал Б Болд, Сангийн зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х Алтантуяа нарт даалгасугай

САЙД

Б БАТЦЭЦЭГ

**“ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ТУСЛАХ САН”-ГИЙН
ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ 3 ДУГААР ХУРЛААР ХЭЛЭЛЦЭН ШИЙДВЭРЛЭСЭН ТУСЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хаана, хэнд олгох	Олгох тусламжийн хэмжээ төгрөгөөр
“Дүрмийн 4.3.1. буюу хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарилыг эх оронд нь буцаах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл садан нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах” гэсэн заалтыг үндэслэн;		
1	БНСУ-д ажил хийж байгаад 2022.03.05-ны өдөр зуурдаар нас барсан иргэн П.Н-ын шарилыг эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
2	БНСУ-д 2016 оноос хойш ажиллаж байгаад 2021.10.10-нд зүрх нь хаагдаж нас барсан иргэн А.Ү-ийн шарилыг эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
3	Франц Улсын Сайнт-Этиенне хотын эмнэлэгт хорт хавдар өвчний улмаас 2022 оны 3 дугаар сарын 21-ний өдөр нас барсан иргэн С.Э-ийн шарилыг эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
4	БНСУ-ын Сөүл хотод зүрхний цочмог шигдээс өвчнөөр 2022.02.28-ны өдөр нас барсан иргэн Ч.А-гийн шарилыг эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
5	БНСУ-ын Чангшин сургуулийн 4 дүгээр курст суралцаж байгаад 2022.03.25-ны өдөр зуурдаар нас барсан иргэн Г.Г-гийн шарилыг нь эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
6	Япон Улсад сурч байгаад 2022.04.13-ны өдөр зуурдаар нас барсан иргэн Б.А-гийн шарилыг эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
7	АНУ-д сурч байгаад 2022.03.19-ны өдөр нас барсан иргэн Б.Э-ны шарилыг эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг	5,000,000 төгрөг
8	Японд сурч байгаад 2022.06.13-нд зуурдаар нас барсан иргэн Г.О-гийн шарилыг нь эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг	5,000,000 төгрөг
4.3.6. хилийн чанадад гэмт хэргийн улмаас хохирсон иргэнтэй холбоотой асуудлыг тухайн улсын холбогдох хууль хяналтын байгууллагаар хянуулах, эрх ашгийг нь хамгаалахад шаардагдах өмгөөлөгч, орчуулагчийг хөлслөх;		
9	Иргэн Э.Х Унгар Улсад ажиллаж амьдарч байгаад 2022.01.17-нд гадны нөлөөтэйгээр нас барсан иргэн Э.Х-гийн хэргийг үнэн зөвөөр шүүлгэхийн тулд хөлсөлж авсан өмгөөлөгчийн зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
“Дүрмийн 4.3.2. заалт буюу хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, алан хядах ажиллагаа, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, сэтгэцийн өвчтэй болсон, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаах” гэснийг үндэслэн;		
10	COVID19 Цар тахлын улмаас хөл хорионд орж санхүүгийн хүнд байдалд орсон БНХАУ-ын Шанхай хотын их сургуулийн магистрантур М.Э-нд,	350,000 төгрөг
11	COVID19 Цар тахлын улмаас хөл хорионд орж санхүүгийн хүнд байдалд орсон БНХАУ-ын Шанхай хотын их сургуулийн магистрантур М.Э-нд,	350,000 төгрөг
Дүн		45,700,000 төгрөг

Нийт дүн **45,700,000** /дөчин таван сая долоон зуун мянга/ төгрөг



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/АГ

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, "Сангийн дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм"-ийн 4 дүгээр зүйл болон Сангийн зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 4 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Энэхүү тушаалын хавсралт жагсаалтад дурдсан нэр бүхий 14 иргэнтэй холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай 56,295,840/тавин зургаан сая хоёр зуун ерэн таван мянга найман зуун дөч/ төгрөгийг "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-гаас гаргахыг Сангийн зөвлөлийн гишүүн, Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Ганбатад зөвшөөрсүгэй.

2. Сангаас гаргах хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, Консулын газрын захирал Б.Болд, Сангийн зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Ганбат нарт даалгасугай.

САЙД



Б.БАТЦЭЦЭГ

101229268

**“ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ТУСЛАХ САН”-ГИЙН
ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ 4 ДҮГЭЭР ХУРЛААР ХЭЛЭЛЦЭН ШИЙДВЭРЛЭСЭН ТУСЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хаана, хэнд олгох	Олгох тусламжийн хэмжээ төгрөгөөр
“Дүрмийн 4.3.1. хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарилыг эх оронд нь буцаах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл садан нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах” гэсэн заалтыг үндэслэн;		
1	Ходоодны хорт хавдар өвчний улмаас БНСУ-д 2022.05.15-ны өдөр нас барсан иргэн Ц.Г-ийн шарилыг чандарлаж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
2	Камбожид нас барсан Монгол Улсын иргэн Т.О-гийн шарилыг чандарлуулж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг болох,	14,058,840 төгрөг
3	БНСУ-ын Өмнөд Чүнчон мужийн Сосаны эмнэлэгт нас барсан иргэн Ч.Б-ийн шарилыг чандарлуулж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг болох,	5,000,000 төгрөг
4	Камбожид 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдөр нас барсан иргэн Г.М-ийн шарилыг чандарлуулж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг болох,	5,000,000 төгрөг
5	БНСУ-ын Улсан хотын Дунганг Эмнэлэгт “сүрьеэгийн гаралтай мененгит” оноштойгоор эмчлүүлж байгаад 2022.07.01-нд нас барсан иргэн Б.С-ын шарилыг чандарлуулж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг болох,	5,000,000 төгрөг
6	Австри улсад оршин сууж байгаад 2022.07.16-ны өдөр Австрийн Грац хотын эмнэлэгт нас барсан Д.С-ын шарилыг чандарлуулж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг болох,	2,900,000 төгрөг
7	БНСУ-д 2022.08.08-ны өдөр нас барсан иргэн Т.М-ийн шарилыг чандарлуулж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг болох,	5,000,000 төгрөг
4.3.3. хилийн чанадад хорих ял эдэлж байгаад, эсхүл албадан саатуулагдаж байгаад суллагдсан иргэнийг эх оронд нь буцаах гэснийг үндэслэн;		
8	БНСУ-ын Чонжүгийн хорих ангид хүмүүжиж байгаад хугацаанаас өмнө суллагдсан иргэн Б.С-ийн Монгол руу буцах зардал	780,000 төгрөг
4.3.4. гэмт хэргийн улмаас хохирсон буюу эд хөрөнгөө хаяж гээгдүүлсний улмаас төлбөрийн чадваргүй болсон иргэнийг эх оронд нь буцаах;		
9	БНХАУ -ын Хайлаар хотод байнга оршин суудаг бөгөөд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэн Г.Г, түүний хүү Х-ийн Монгол руу буцах зардал	936,000 төгрөг
10	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2022 оны 4 дүгээр сард 3 сар хоригдох ял авсан У.А-ын Монгол руу буцах зардал	2,500,000 төгрөг
4.3.6. хилийн чанадад гэмт хэргийн улмаас хохирсон иргэнтэй холбоотой асуудлыг тухайн улсын холбогдох хууль хяналтын байгууллагаар хянуулах, эрх ашгийг нь хамгаалахад шаардагдах өмгөөлөгч, орчуулагчийг хөлслөх;		
11	Ш.А-ийн хэргийн шүүх хурал 2022 оны 10 дугаар сарын 19-нд Малайзад болохтой холбогдуулан өмгөөлөгчийн төлбөр	5,000,000 төгрөг

“Дүрмийн 4.3.2. заалт буюу хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, алан хядах ажиллагаа, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, сэтгэцийн өвчтэй болсон, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаах” гэснийг үндэслэн;		
12	ОХУ-ын Эрхүү хотын хүнсний зах дээрээс түргэн тусламжийн машинаар эмнэлэгт ухаангүй хүргэгдэн очиж эмчлүүлсэн Ж.С-ийн Монгол руу буцах зардал	421,000 төгрөг
13	ОХУ-ын Москва хотод хууль бусаар оршин сууж байгаа Монгол Улсын иргэн Д.М-ын Монгол руу буцах зардал	1,700,000 төгрөг
14	Төрөлхийн бүдүүн гэдэсний цорго битүү төрсөн Б.Б /2021.09.03-ны өдөр төрсөн, эр/-ийн БНСУ-ын “Самсунг” эмнэлэгт хагалгаа хийлгэх зардлын тодорхой хэсэг болох,	3,000,000 төгрөг
Дүн		56,295,840 төгрөг

Нийт дүн **56,295,840** тавин зургаан сая хоёр зуун ерэн таван мянга найман зуун дөч/ төгрөг



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 8/98

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, "Сангийн дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм"-ийн 4 дүгээр зүйл болон Сангийн зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 5 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Энэхүү тушаалын хавсралтад дурдсан нэр бүхий 15 иргэнтэй холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шаардлагатай 54,420,000 /тавин дөрвөн сая дөрвөн зуун хорин мянга/ төгрөгийг "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-гаас, хилийн чанадад ял эдэлж байгаа 132 иргэнд Монгол Улсын ДТГ-уудаас эргэж дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай 42,839,907.50 /дөчин хоёр сая найман зуун гучин есөн мянга есөн зуун долоон төгрөг тавин мөнгө/ төгрөгийг Улсын онцгой комиссын даргын 2020 оны 08 дугаар сарын 18-ны шийдвэрийн дагуу Иргэдэд туслах санд төвлөрүүлсэн 300 сая төгрөгийн хөрөнгөөс тус тус гаргахыг Сангийн зөвлөлийн гишүүн, Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Ганбатад зөвшөөрсүгэй.

2. Сангаас гаргах хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, Консулын газрын захирал Б.Болд, Сангийн зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Ганбат нарт даалгасугай.

САЙД



Б.БАТЦЭЦЭГ

101220323

**“ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ТУСЛАХ САН”-ГИЙН
ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ 5 ДУГААР ХУРЛААР ХЭЛЭЛЦЭН ШИЙДВЭРЛЭСЭН ТУСЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хаана, хэнд олгох	Олгох тусламжийн хэмжээ төгрөгөөр
Нэг. Иргэдэд туслах сангийн 2022 оны төсвөөс:		
“Дүрмийн 4.3.1. буюу хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарилыг эх оронд нь буцаах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл садан нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах” гэсэн заалтыг үндэслэн;		
1	БНСУ-д 2022.08.12-ны өдөр нас барсан Б.М-ийн эмчилгээний зардал болон оршуулгын зардлын тодорхой хэсэг	5,500,000 төгрөг
2	Камбожид нас барсан Монгол Улсын иргэн Т.О-гийн шарилыг чандарлуулж эх оронд нь авч ирэх зардлыг барагдуулахад гарсан ам.долларын ханшны зөрүүгийн төлбөр,	1,050,000 төгрөг
3	Их Британи улсад зүрх, голт ба хавсын өмөн шинж тэмдэгтэйгээр 2022.09.07-ны өдөр нас барсан иргэн Б.Б-ний шарилыг чандарлуулж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,500,000 төгрөг
4	БНСУ-д 2022 оны 10 дугаар сарын 02-ны өдөр нас барсан иргэн Э.Ө-гийн шарилыг чандарлуулж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,500,000 төгрөг
5	АНУ-ын Чикаго хотын дагуул хот Нортбрүүк дэх гэртээ 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдөр гэмт халдлагад өртөж нас барсан иргэн А.Б-гийн шарилыг чандарлуулж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,500,000 төгрөг
6	АНУ-ын Virginia мужийн Roanoke хотод ажиллаж амьдарч байгаад нас барсан иргэн Э.Б-ийн шарилыг чандарлуулж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,500,000 төгрөг
7	БНСУ-д 2022 оны 9 дүгээр сарын 30-нд зуурдаар нас барсан иргэн Э.Д-ний шарилыг чандарлуулж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,500,000 төгрөг
“Дүрмийн 4.3.2. заалт буюу хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, алан хядах ажиллагаа, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, сэтгэцийн өвчтэй болсон, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаах” гэснийг үндэслэн;		
8	Бүгд Найрамдах Серби Улсын Белград хотын цагаач иргэдийн түр байранд байгаа Монгол Улсын иргэн Л.У-т үзүүлэх дэмжлэг,	850,000 төгрөг
9	Украины Донецк мужид 1988 онд суралцахаар очсоноос хойш байнга амьдарч байгаа иргэн Ж.Э-лын Монгол руу буцах зардал,	1,000,000 төгрөг
10	БНСУ-д амьдарч буй иргэн Б.У-гийн Монгол руу буцах зардал,	1,000,000 төгрөг
4.3.3. хилийн чанадад хорих ял эдэлж байгаад, эсхүл албадан саатуулагдаж байгаад суллагдсан иргэнийг эх оронд нь буцаах; гэснийг үндэслэн;		

11	Малайзад ял эдэлж байгаад суллагдсан иргэн Д.Х түүний охин Х.С нарын Монгол руу буцах болон тэдний бичиг баримтыг илгээсэн шуудангийн зардал,	5,150,000 төгрөг
12	Малайз Улсад хулгайн хэргээр хорих ял эдэлсэн иргэн С.А-ны Монгол руу буцах зардал	2,500,000 төгрөг
13	ОХУ-ын Буриадын Гадаадын иргэн харьяатын албанаас 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Монгол руу буцаасан иргэн Ж.Б-т үзүүлэх дэмжлэг,	200,000 төгрөг
4.3.4. гэмт хэргийн улмаас хохирсон буюу эд хөрөнгөө хаяж гээгдүүлсний улмаас төлбөрийн чадваргүй болсон иргэнийг эх оронд нь буцаах;		
14	БНСУ-ын Кёнги мужийн Пёнтак хотод байрлах зочид буудалд ажиллаж байхдаа 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдөр бэлгийн хүчирхийлэлд өртсөн иргэн Г.Г-ийн өмгөөллийн зардлын тодорхой хэсэг,	4,000,000 төгрөг
4.3.7. хилийн чанадад хорих ял эдэлж байгаа иргэнийг дипломат төлөөлөгчийн газраас эргэх;		
15	Унгарт саатуулагдан шалгагдаж байгаа 4 иргэнийг эргэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах тохиолдолд давж заалдах шатны шүүх хуралд ЭСЯ-наас оролцох төлөөллийн замын зардал,	5,670,000 төгрөг
Дүн		54,420,000 төгрөг
Хоёр: Санд төвлөрүүлсэн 300 сая төгрөгнөөс:		
4.3.7. хилийн чанадад хорих ял эдэлж байгаа иргэнийг дипломат төлөөлөгчийн газраас эргэх;		
16	Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны консулын тойрогт ял эдэлж байгаа 6 иргэнийг эргэж дэмжлэг үзүүлэх зардал	6,084,000 төгрөг
17	Монгол Улсаас БНХАУ-ын Шанхай хотод суугаа ЕКГ-аас консулын тойрогт ял эдлэж буй 2 иргэнийг эргэж дэмжлэг үзүүлэх зардал	940,000 төгрөг
18	Монгол Улсаас БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод суугаа ЕКГ-ын хариуцсан тойрогт хоригдож буй 53 иргэнийг эргэж дэмжлэг үзүүлэх зардал	11,520,907.50 төгрөг
19	Монгол Улсаас БНХАУ-ын Хонгконг хотод суугаа ЕКГ-аас консулын тойрогт ял эдлэж буй 13 иргэнийг эргэж дэмжлэг үзүүлэх зардал	2,200,000 төгрөг
20	Монгол Улсаас БНХАУ-ын Манжуур хотод суугаа КГ-аас консулын тойрогт ял эдлэж буй болон гадуур батлан даалтад байгаа 2 иргэнийг эргэж дэмжлэг үзүүлэх зардал	940,000 төгрөг
21	Монгол Улсаас ОХУ-ын Улаан-Үд хотод суугаа ЕКГ-аас консулын тойрогт ял эдлэж буй 1 иргэнийг эргэж дэмжлэг үзүүлэх зардал	455,000 төгрөг
22	Монгол Улсаас АНУ-ын Сан Франциско хотод суугаа ЕКГ-аас консулын тойрогт ял эдлэж буй 1 иргэнийг эргэж дэмжлэг үзүүлэх зардал	510,000 төгрөг
23	Монгол Улсаас БНТУ-ын Истанбул хотод суугаа ЕКГ-аас консулын тойрогт ял эдлэж буй 7 иргэнийг эргэж дэмжлэг үзүүлэх зардал	3,870,000 төгрөг
24	Монгол Улсаас Япон Улсад суугаа ЭСЯ-ны консулын тойрогт ял эдэлж байгаа 4 иргэнийг эргэж дэмжлэг үзүүлэх зардал	2,840,000 төгрөг
25	Монгол Улсаас Япон Улсын Осако хотод суугаа ЕКГ-аас консулын тойрогт ял эдлэж буй 1 иргэнийг эргэж дэмжлэг үзүүлэх зардал	930,000 төгрөг
26	Монгол Улсаас БНСВУ-д суугаа ЭСЯ-ны консулын тойрогт ял эдэлж байгаа 7 иргэнийг эргэж дэмжлэг үзүүлэх зардал	4,050,000 төгрөг
27	Монгол Улсаас БНСУ-д суугаа ЭСЯ-ны консулын тойрогт ял эдэлж байгаа 26 иргэнийг эргэж дэмжлэг үзүүлэх зардал	5,200,000 төгрөг

28	Монгол Улсаас ОХУ-д суугаа ЭСЯ-ны консулын тойрогт ял эдэлж байгаа 11 иргэнийг эргэж дэмжлэг үзүүлэх зардал	3,300,000 төгрөг
Дүн		42,839,907.50 төгрөг

Нийт дүн 97,259,907.50 /ерэн долоон сая хоёр зуун тавин есөн мянга есөн зуун долоон төгрөг тавин мөнгө/
төгрөг